



**МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ**

2008 оны 10 сарын 22 өдөр

Дугаар 212

Улаанбаатар хот

**“Урт хугацааны даатгагчийг татан буулгах, дахин  
хөрөнгөжүүлэх үйл ажиллагааг явуулах журам”  
батлах тухай**

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Даатгалын тухай хуулийн 14.2.18 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос **ТОГТООХ** нь:

1. “Урт хугацааны даатгагчийг татан буулгах, дахин хөрөнгөжүүлэх үйл ажиллагааг явуулах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэ тогтоолоор батлагдсан журмын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Даатгалын газар /С.Ганболд/-т, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

## **УРТ ХУГАЦААНЫ ДААТГАГЧИЙГ ТАТАН БУУЛГАХ, ДАХИН ХӨРӨНГӨЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЯВУУЛАХ ЖУРАМ**

### **НЭГ. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү журмын зорилго нь Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-ноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгээр Монгол Улсад болон Монгол Улсаас гадаад улсын нутаг дэвсгэрт урт хугацааны даатгалын үйл ажиллагаа явуулж байгаа компанийг Даатгалын тухай хуулийн 14.2.18-д заасан үндэслэлээр татан буулгах, дахин хөрөнгөжүүлэхтэй холбогдсон харилцааг Дампуурлын тухай хууль болон Компанийн тухай хуулиас гадуур нарийвчлан зохицуулахад оршино.

1.2. Энэ журамд хэрэглэсэн нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.2.1. Энэ журмын 3.1.3-т заасан шаардлагатай ур чадвар, дадлага туршлагатай гэдэгт хууль, эдийн засаг, санхүүгийн дээд боловсролтой, даатгалын салбарт 3-аас доошгүй жил ажилласан, Хорооноос баталсан даатгагчийн болон даатгалын мэргэжлийн оролцогчийн “Тохиромжтой этгээдийг тодорхойлох заавар”-т заасан шаардлагыг хангасан этгээдийг хэлнэ.

*/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 202 дугаар тогтоолоор өөрчилөн найруулсан/*

1.2.2. Даатгагчийг төлбөрийн чадваргүйд тооцох гэдэгт Хорооноос баталсан даатгалын компанийн төлбөрийн чадварыг тооцох, түүнд хяналт тавих талаарх харилцааг зохицуулсан холбогдох журамд, Дампуурлын тухай хуулийн 4.1-д заасныг ойлгоно.

*/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 202 дугаар тогтоолоор өөрчилөн найруулсан/*

1.2.3. “Даатгагч” гэдэгт Даатгалын тухай хуулийн 4.1.2-т заасныг ойлгоно.

### **ХОЁР. Даатгагчийг татан буулгах**

2.1. Даатгагчийг дараах тохиолдолд татан буулгана:

2.1.1. Хувь нийлүүлэгчдийн шийдвэрийг үндэслэн Хорооноос өгсөн зөвшөөрлийн дагуу;

2.1.2. Шүүхийн шийдвэрээр.

### **ГУРАВ. Даатгагчийг хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэрээр татан буулгах**

3.1. Энэ журмын 2.1.1-д заасны дагуу компанийн хувь нийлүүлэгчдийн хурлаас даатгагч нь татан буулгах тухай хүсэлтээ гаргаж байгаа тохиолдолд дараах баримт бичгийг эх хувиар нь эсхүл нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг Хороонд ирүүлнэ:

3.1.1. Даатгагчийг татан буулгах зөвшөөрөл хүсэх тухай албан бичиг;

3.1.2. Даатгагчийг татан буулгахыг зөвшөөрсөн тухай хувь нийлүүлэгчдийн дийлэнх олонхиор баталсан шийдвэр;

3.1.3. Компанийн хувь нийлүүлэгчдийн хурлаас даатгагчийг татан буулгах комиссыг томилсон тухай шийдвэр болон комиссын гишүүнээр томилуулахаар санал болгож буй этгээдийн нэрсийн жагсаалт, тэднийг шаардлагатай ур чадвар, дадлага туршлагатай болохыг нотлох баримт бичиг;

3.1.4. Даатгагчийг татан буулгах болсон үндэслэл, шалтгааны талаарх тайлбар;

3.1.5. Хууль болон гэрээгээр тогтоосон хугацаа нь дуусгавар болоогүй, хүчин төгөлдөр гэрээг хэрхэн шийдвэрлэсэн талаарх санхүүгийн болон бусад нотлох баримт бичиг;

3.1.6. Даатгагч татан буулгах зөвшөөрөл хүссэн тухай шийдвэрийг даатгуулагчдад мэдэгдсэнийг нотлох баримт бичиг;

3.1.7. Хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцэж, аудитын байгууллагаар баталгаажуулсандаатгагчийн санхүүгийн тайлан;

3.1.8. Татан буулгах төлөвлөгөө;

3.1.9. Даатгагч татан буулгах хүсэлтээ гаргасан талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлснийг нотлох баримт бичиг;

3.1.10. Шаардлагатай тохиолдолд Хороо даатгагчаас нэмэлт мэдээ мэдээлэл, баримт шаардаж болно.

3.2. Энэ журмын 3.1.8-д заасан татан буулгах төлөвлөгөөнд дараах зүйлийг тусгасан байна:

3.2.1. Даатгуулагч нараас ирүүлсэн нөхөн төлбөр болон нэхэмжлэлийн шаардлагыг хэрхэн барагдуулах, түүний хугацаа, дараалал. Нэхэмжлэл гаргах хугацаа нь 3 сараас багагүй, 6 сараас ихгүй байх;

3.2.2. Даатгуулагч нарын эрх ашгийг хамгаалах үүднээс даатгагч гэрээний дагуу даатгуулагчдад олгох ёстой нөхөн төлбөр, хууль болон гэрээгээр тогтоосон хугацаа нь дуусгавар болоогүй, хүчин төгөлдөр гэрээг бүхэлд нь буюу хэсэгчлэн бусад даатгалын компанид хэрхэн шилжүүлэх талаар;

3.2.2.1. Даатгагч хууль болон гэрээгээр тогтоосон хугацаа нь дуусгавар болоогүй, хүчин төгөлдөр гэрээг шилжүүлэхдээ Хорооноос баталсан Даатгагчаас үйл ажиллагааныхаа тодорхой хэсгийн бусдад шилжүүлэх болон нэгтгэх үед гаргах өргөдлийг хянан шийдвэрлэх журамын дагуу шилжүүлэх ба гэрээг шилжүүлэн авч буй даатгагч Хорооны зөвшөөрөл авсан байна.

*/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 202 дугаар тогтоолоор өөрчилөн найруулсан/*

3.3. Гэрээний үлдэгдлийг шилжүүлэн авах даатгагч байхгүй тохиолдолд даатгуулагч нэг бүртэй харилцан тохирч, гэрээг байгуулах үеийн төгрөгийн ханшийг

бууруулахгүйгээр даатгалын хураамжийг даатгуулагчид буцаан олгож, гэрээний үлдэгдлийг эцэслэн шийдвэрлэсэн байх шаардлагатай.

3.4.Татан буулгах төлөвлөгөөний хэрэгжилтэд Хорооны Ажлын алба хяналт тавина.  
*/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 202 дугаар тогтоолоор өөрчилөн найруулсан/*

3.5.Татан буулгах төлөвлөгөөг хэрэгжүүлж дууссан тухай тайланг татан буулгах комисс гаргаж, Хороонд танилцуулна.

3.6.Даатгагчийг татан буулгах тухай компанийн хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын 5 өдрийн дотор энэ журмын 3.1-д заасан баримт бичгийг бүрдүүлэн Хороонд хандана.

3.7.Компанийн хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэрээр Хороонд хандаж татан буулгах тухай хүсэлт гаргасан даатгагч шийдвэр гарсан өдрөөс хойш шинээр даатгалын гэрээ байгуулахыг хориглоно.

3.8.Даатгагчаас Хороонд ирүүлсэн татан буулгах тухай хүсэлт, баримт бичгийн үнэн зөвийг тэдгээрт гарын үсэг зурсан албан тушаалтан хариуцна.

3.9.Энэ журмын 3.1-д заасны дагуу Даатгагчаас Хороонд хандаж гаргасан хүсэлтийг Хороо ажлын 21 өдрийн дотор хянаж шийдвэрлэнэ.

3.10.Урт хугацааны даатгагч Дампуурлын тухай хууль болон бусад хуулийн дагуу татан буугдахад даатгагчийн урт хугацааны санг зөвхөн Даатгалын тухай хуулийн 80 дугаар зүйлд үндэслэн Хорооноос баталсан журмын дагуу зарцуулна.

3.11.Энэ журмын 3.1-д заасан баримт бичгийг бүрэн гүйцэд, үнэн зөв бүрдүүлж Хороонд ирүүлсэн өдрөөс эхэлж шийдвэрлэх хугацааг тооцно.

3.12.Хороо дараах тохиолдолд компанийн хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэрээр даатгагчийг татан буулгахаас татгалзана:

3.12.1.Даатгагчийг татан буулгах тухай хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэр нь хууль тогтоомж зөрчсөн, даатгуулагчийн эрх ашигт сөргөөр нөлөөлөхөөр бол;

3.12.2.Даатгуулагчтай байгуулсан гэрээний үлдэгдлийг шийдвэрлэж дуусаагүй бол;

3.12.3.Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт нь Хорооноос баталсан даатгалын компанийн төлбөрийн чадварыг тооцох, түүнд хяналт тавих талаарх харилцааг зохицуулсан холбогдох журамд заасан шаардлагыг хангаагүй;

*/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 202 дугаар тогтоолоор өөрчилөн найруулсан/*

3.12.4.Татан буулгах комиссын гишүүнээр томилуулахаар санал болгож буй этгээд нь ийнхүү ажиллахад шаардлагатай ур чадвар, дадлага туршлагагүй.

**ДӨРӨВ. Хороо урт хугацааны даатгагчийг татан буулгах тухай нэхэмжлэлийг шүүхэд гаргах**

4.1.Хороо энэ журмын 2.1.2-т заасны дагуу дараах тохиолдолд урт хугацааны даатгагчийг татан буулгах тухай нэхэмжлэлийг шүүхэд гаргана:

4.1.1.Даатгагч төлбөрийн чадваргүй болсон;

4.1.2.Даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон.

4.2.Хороо тусгай зөвшөөрөлгүйгээр даатгалын үйл ажиллагаа эрхэлж байгаа, эсхүл эрхэлж байсан хуулийн этгээдийг татан буулгуулах тухай нэхэмжлэлийг шүүхэд гаргаж болно.

#### **ТАВ. Төлбөрийн чадваргүй болж болзошгүй даатгагчид Хорооноос авах арга хэмжээ**

5.1.Хороо дор дурдсан нөхцөл байдлын аль нэг нь бүрдсэн тохиолдолд даатгагчийг төлбөрийн чадваргүй болж болзошгүй гэж үзэн албадлагын арга хэмжээ авна:

5.1.1.Даатгагч нь ~~Хорооны 2008 оны 65 дугаар тогтоолоор батлагдсан “Урт хугацааны даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам” аар тогтоосон төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийг 2 улирал дараалан хангаагүй;~~

*/Энэ заалтын зарим хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 202 дугаар тогтоолоор хассан/*

5.1.2.Даатгалын тухай хуулийн 36.1.1-д заасны дагуу аудитор даатгагчийг төлбөрийн чадваргүй болж болзошгүй байгаа талаар Хороонд мэдэгдсэн.

5.2.Энэ журмын 5.1-д заасан үндэслэлээр тухайн даатгагчийн хэвийн үйл ажиллагааг хангах, санхүүгийн байдлыг нь сайжруулах зорилгоор Хороо дараах албадлагын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

5.2.1.Төлбөрийн чадваргүй болж болзошгүй болсон даатгагчийн даатгалын тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх;

5.2.2.Даатгалын тухай хуулийн 68.1.5-д заасны дагуу даатгалын үйл ажиллагааг зохистой явуулах талаар зөвлөх үүрэг бүхий дадлага туршлагатай мэргэжилтэнг томилох;

5.2.3.Шаардлагатай бол Компанийн дансуудад хаалт хийх.

#### **ЗУРГАА. Хорооноос томилогдсон мэргэжилтний бүрэн эрх, авах арга хэмжээ**

6.1.Хорооноос томилогдсон зөвлөх үүрэг бүхий мэргэжилтэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

6.1.1.Даатгалын үйл ажиллагааны нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн үзүүлэлтийг хянаж, зохицуулах арга хэмжээ авах;

6.1.2.Тухайн даатгагчаас урьд нь даатгуулагчтай хийсэн даатгалын гэрээний нөхцөл нь даатгагчийн тухайн үеийн нөхцөл байдлаас өөрөөр тогтоогдож, даатгагчийн эрх ашигт сөргөөр нөлөөлсөн гэж үзвэл уг гэрээнд өөрчлөлт оруулах, цуцлах асуудлыг шийдвэрлэх;

6.1.3.Даатгагчийн нэрийн өмнөөс нэхэмжлэл гаргах;

6.1.4.Шаардлагатай гэж үзвэл даатгагчийн дүрэм болон бизнес төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах.

6.2.Мэргэжилтний гаргасан шийдвэрийг тухайн даатгагч, түүний салбар биелүүлэх үүрэгтэй.

6.3.Мэргэжилтний албан ёсны зөвшөөрөлгүйгээр тухайн даатгагчийн нэрийн өмнөөс болон тухайн даатгагчийн зардлаар хийсэн ажил гүйлгээг хүчингүйд тооцно.

6.4.Даатгагчийн хэвийн үйл ажиллагаа хангагдсан нөхцөлд, даатгагчид хийсэн үйл ажиллагааны тайланг Хороонд танилцуулж, тухайн даатгагчид тогтоосон хязгаарлалтыг хэсэгчлэн, эсхүл бүрмөсөн хүчингүй болгох болон тусгай зөвшөөрлийг сэргээх асуудлыг Хороонд тавьж шийдвэрлүүлнэ.

6.5.Мэргэжилтний томилогдсон хугацаанд тухайн даатгагчийн дүрэмд оруулсан нэмэлт өөрчлөлт хүчинтэй хэвээр үлдэнэ.

### **ДОЛОО. Төлбөрийн чадваргүй болсон даатгагчид Хорооноос авах арга хэмжээ**

7.1.Хороо дор дурдсан нөхцөл байдлын аль нэг нь бүрдсэн тохиолдолд даатгагчийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, энэ журмын 4.1.1-д заасан үндэслэлээр даатгагчийг татан буулгах нэхэмжлэлийг шүүхэд гаргана:

7.1.1.Даатгагч нь даатгуулагч, харилцагч, бусад үүргийн гүйцэтгэлийг шаардах эрх бүхий этгээдийн мөнгийг тэдний анхны шаардлагаар гарган өгч чадахгүй болсон;

7.1.2.Мэргэжилтэн томилогдсон хугацаанд даатгагчийн хэвийн үйл ажиллагаа хангагдаагүй гэж үзвэл;

7.1.3.Даатгалын тухай хуулийн 36.1.1-т заасны дагуу аудитор даатгагчийг төлбөрийн чадваргүй болсон талаар Хороонд мэдэгдсэн.

### **НАЙМ. Даатгагчийг татан буулгах тухай нэхэмжлэлийг шүүхэд гаргахад Хорооны оролцох оролцоо**

8.1.Энэ журмын 7.1-д заасан үндэслэлээр даатгагчийг татан буулгах тухай нэхэмжлэлийг шүүхэд гаргахад Хороо дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

8.1.1.Даатгуулагчдын эрх ашгийг хамгаалах үүднээс даатгагчийн талаар тайлбар, мэдээлэл өгөх;

8.1.2.Тохирох мэргэжил, дадлага туршлага бүхий хүнийг хэрэг гүйцэтгэгчээр томилуулахаар санал тавих;

8.1.3. Дампуурлын тухай хуулийн 8.1-д заасан нэхэмжлэгчдийн хуралд оролцох;

8.1.4. Хэрэг гүйцэтгэгчийн мэдээлэл, дүгнэлттэй танилцах;

8.1.5. Дампуурлын тухай хуулийн 8.2-т заасны дагуу нэхэмжлэгчдийн хурлаас хэрэг гүйцэтгэгчид томилуулахаар санал болгосон этгээдийг өөрчлөх тухай саналыг шүүхэд тавих.

8.2. Хороо шүүхэд гаргаж буй тайлбар, мэдээллийн бодит үнэнийг өөрөө хариуцна.

8.3. Даатгагчид дампуурлын хэрэг үүсгэхтэй холбогдсон Даатгалын тухай хууль болон энэ журмаар зохицуулаагүй харилцааг Дампуурлын тухай хуулийн дагуу зохицуулна.

8.4. Даатгагчийг татан буулгахаар нэхэмжлэл гаргасан тухай шүүхээс ирүүлсэн мэдэгдлийг аваад Хороо нэхэмжлэлтэй холбоотой аливаа асуудлыг хэлэлцэхэд оролцох, тайлбар өгөх эрхтэй.

8.5. Дампуурлын тухай хуулийн 5.1.2-т заасан үндэслэлээр даатгагчид дампуурлын хэрэг үүсгэсэн бол Хороо энэ журмын 8.1-д заасан эрх эдэлж, үүрэг хүлээж оролцоно.

8.6. Татан буугдаж буй даатгагчид тавигдах шаардлагыг Иргэний хуулийн 32.5-д заасан дарааллын дагуу хангана.

8.7. Энэ журмын 8.6-д заасан шаардлагыг хангахдаа эхний дарааллын төлбөрийг бүрэн барагдуулсны дараа түүний дараагийн дарааллын төлбөрийн шаардлагыг хангах зарчмыг баримтална.

### **ЕС. Тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон даатгагчийг татан буулгах нэхэмжлэлийг шүүхэд гаргах**

9.1. Энэ журмын 4.1.2-т заасан үндэслэлээр Хороо даатгагчийг татан буулгах тухай нэхэмжлэлийг шүүхэд гаргана.

9.2. Хороо нь татан буулгах тухай нэхэмжлэлийг шүүхэд гаргахдаа дараах баримт бичгийг хавсаргана:

9.2.1. Даатгагч даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Хорооноос авахдаа хуурамч баримт бичиг бүрдүүлснийг нотлох баримт бичиг;

9.2.2. Хорооноос авсан тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг удаа дараа буюу ноцтой зөрчсөнийг нотлох баримт бичиг;

9.2.3. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлийг арилгах талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүйг нотлох баримт бичиг.

9.3. Энэ журмын 9.1-д зааснаар Хороо нь нэхэмжлэл гаргасан бол Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэхэмжлэгчийн эдлэх эрхийг эдэлж, үүрэг хүлээнэ.

### **АРАВ. Даатгагчийг дахин хөрөнгөжүүлэх**

10.1. Даатгагчийг дахин хөрөнгөжүүлэх тухай төлөвлөгөөг Дампуурлын тухай хуулийн 23.1-д заасан этгээд гаргаж болно.

10.2. Энэ журмын 10.1-д заасан даатгагчийг дахин хөрөнгөжүүлэх хүсэлт гаргаж буй этгээд дараах баримт бичгийг эх хувиар, эсхүл нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг Хороонд ирүүлнэ:

10.2.1. Даатгагчийг дахин хөрөнгөжүүлэх гэж буй этгээдийн хөрөнгөжүүлэх тухай хүсэлт, дэлгэрэнгүй анкет;

10.2.2. Даатгагчийг дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөө;

10.2.3. Дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөг хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэр хууль ёсны орлогоос бүрдсэн болохыг нотлох баримт бичиг, гарал үүслийн тодорхойлолт;

10.2.4. Хүсэлт гаргасан этгээдийн өр төлбөртэй эсэхийг тодорхойлсон Татварын албаны болон Банкны өр барагдуулах албаны тодорхойлолт;

10.2.5. Хөрөнгөжүүлэх гэж буй этгээдийн арилжааны банкинд өр төлбөртэй эсэхийг тодорхойлсон Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолт;

10.2.6. Шаардлагатай тохиолдолд Хороо хүсэлт гаргагчаас нэмэлт мэдээ мэдээлэл, баримт шаардаж болно.

10.3. Энэ журмын 10.2.2-т заасан дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөнд Дампуурлын тухай хуулийн 24.2-т заасан үйл ажиллагааг тодорхой тусгана.

10.4. Шаардлагатай тохиолдолд Хороо хүсэлт гаргагчаас нэмэлт мэдээ мэдээлэл, баримт шаардаж болно.

10.5. Хороо дахин хөрөнгөжүүлэх хүсэлт гаргагчаас ирүүлсэн дахин хөрөнгөжүүлэх тухай хүсэлт болон төлөвлөгөөг зөвшөөрөх эсэх асуудлыг Хороо ажлын 21 өдрийн дотор хянаж шийдвэрлэнэ.

10.6. Хороо дараах үндэслэлээр дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөнд зөвшөөрөл өгөхөөс татгалзана:

10.6.1. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх нь даатгуулагчдын эрх ашигт сөргөөр нөлөөлөхөөр бол;

10.6.2. Ирүүлсэн баримт бичиг нь холбогдох хууль, журамд заасан шаардлага хангаагүй.

### **АРВАН НЭГ. Хяналт, хариуцлага**

11.1. Хороо нь энэ журмын биелэлтэд хяналт тавих бөгөөд зөрчсөн этгээдэд Даатгалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.